



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 17 өдөр

Дугаар 5/08

Ховд

Албан үүргийг түр орлон  
гүйцэтгүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төрийн албаны тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.8, 43 дугаар зүйлийн 43.1, 43.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Ажлын зайлшгүй шаардлагаар хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг нь Авлигатай тэмцэх газрын 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 05/4229 тоот албан бичгээр хянагдаж ирсэн Вашагийн Сайнбаярыг Боловсрол, шинжлэх ухааны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилсугай.

2. В.Сайнбаярт Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 488 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан зохих цалингийн сүлжээгээр цалинжуулж, хууль тогтоомжид заагдсан холбогдох нэмэгдлүүдийг сар бүр бодож олгохыг Боловсрол, шинжлэх ухааны газрын нягтлан бодогч (Б.Уугантуяа)-д зөвшөөрсүгэй.

3. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, ашиг сонирхлын зөрчил үүссэн тохиолдол бүрт тайлбар, мэдүүлэг гаргаж ажиллахыг В.Сайнбаярт даалгасугай.

4. Боловсрол, шинжлэх ухааны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэж байсан Б.Алтангэрэлийг зохих ажлын байраар хангаж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (В.Сайнбаяр)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Э.БОЛОРМАА

8400001 0366

Zah B/08 Ba